



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/145

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн цаг агаарт зориудаар нөлөөлөх Онги бороо 1,2,3,4 экспедицийн 2023 оны үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 20,918,000 (Хорин сая есөн зуун арван найман мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0248

D:My Doc. Zahirambj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 20-ны өдрийн 03 дугаар
захирамжийн хавсралт



№	Бараа материал, нэр төрөл	Төсөвт өртөг (мянган төгөгр)
1.	Онги бороо 1,2,3,4 экспедицийн үйл ажиллагаанд шаардлагатай шатахууны зардал 16000-18000 км. (Тооцоог 2008 оноос хойш процессыг дундажлан гаргасан)	6,392,000
2.	Автомашин засвар үйлчилгээ (Пургон автомашины доторлогоо болон тос масло тосолын үйлчилгээ)	2500,000
3.	Онги-бороо 1,2,3,4 экспедицийн үйл ажиллагаанд явсан хүмүүсийн албан томилолт (нийт 20 хүний давхардсан болон ээлжээр гарах сард 3-5 удаагийн процесс дээр ажиллах нийт 3-9 сард нэг хүнд 12 өдөр ноогдох томилолт, тооцоог 2008 оноос хойш процессыг дундажлан гаргасан)	5800,000
4.	Үүрэн холбооны зардал, бичиг хэрэг сард (343000*6)	2060,000
5.	Богд,Хархорин,Хужирт өртөөнд синоптик инженерүүдэд үүлний зураг, аэросиноптик нөхцөл үүлний шилжилт хөдөлгөөн газар орчны зураг харахад шаардлагатай супер компьютер	4166,000
Нийт дүн		20,918,000

-oOo-